



ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧ НАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл:info@mof.gov.mn
Вэбсайт:www.mof.gov.mn

2020. 10. 19 № 8-116664
танай —ны № —т

Мэдээлэл шинэчлэх тухай

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээг олон нийтэд мэдээлэх талбарыг тусгайлан хөгжүүллээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтад “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах” мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах” гэж заасны дагуу 2019, 2020 онд байгуулсан худалдан авах гэрээг бүрэн оруулна уу.

Түүнчлэн Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 2.1 дэх хэсэгт заасан захиалагчийг төлөөлөн цахим систем /www.tender.gov.mn/-д нэвтрэх эрхийг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор шинэчилж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна. Дээрх өөрчлөлтийг харьяа бүх байгууллагад хүргүүлж холбогдох мэдээллийг шинэчлэх шаардлагатай бөгөөд заасан хугацаанаас өмнө шинэчлээгүй тохиолдолд нэвтрэх эрхийг хүчингүй болгохыг анхаарна уу.



9763004568